

ПРИСТИЙН
ЗЭРЭГТНИЙ
БОЛОН ХАВСРАЛТ
БАЙГУУЛЛАГУУДЫН
УДИРДАГЧДЫН

У Д И Р Д А М Ж

ПРИСТИЙН
ЗЭРЭГТНИЙ
БОЛОН ХАВСРАЛТ
БАЙГУУЛЛАГУУДЫН
УДИРДАГЧДЫН

У Д И Р Д А М Ж

Есүс Христийн Хожмын Үеийн
Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэв.
Солт Лейк Сити, Юта.

Агуулга

Оршил	1
Пристийн Зэрэг	5
Хавсралт Байгууллагууд	13
Сургалтын Хөтөлбөр ба Багшийн Хөгжил	18
Удирдлага	20
Сүмийн Материалуудыг Олж Авах болон Гэр Бүлийн Түүхэнд Мэдээлэл Оруулах	26

Хуваарилалт

Пристийн Зэрэгтний болон Хавсралт Байгууллагуудын Удирдагчдын Удирдамжийг Сүмд шинээр элссэн болон Сүмийн туршлага багатай хүмүүст зориулсан болно. Энэ нь түүнчлэн шинээр байгуулагдсан бүсүүдийн удирдагчдад хэрэгтэй байх болно. Удирдамж нь пристийн зэрэгтний болон хавсралт байгууллагуудын удирдагчдад дуудлагаа биелүүлэхэд нь туслах зарчмууд хийгээд практик үйл ажиллагааг тайлбарласан юм.

© 2001 by Intellectual Reserve, Inc.
All rights reserved
АНУ-д хэвлэв

Англи эхийн зөвшөөрөл: 3/01
Орчуулгын зөвшөөрөл: 3/01
Priesthood and Auxiliary Leaders' Guidebook-ийн орчуулга
Mongolian

Оршил

Пристийн зэрэгтний болон хавсралт байгууллагуудын удирдагчид өөрсдийн дуудлагын үүрэг хариуцлагууд хийгээд тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэхийг мэдэж авахад нь зориулж Сүм энэхүү удирдамжийг бэлтгэсэн болно. Бүх удирдагчид хийгээд Сүмийн бусад гишүүд, бүх хүмүүсийг “Христэд ирж, түүнд төгөлдөржихөд” (Моронай 10:32) урих явдал болох Сүмийн зорилгыг хэрэгжүүлэхэд туслах ёстой. Энэ зорилгыг хэрэгжүүлэхийн тулд удирдагчид гишүүдэд ийн тусалдаг:

- Есүс Христийн сайн мэдээг бүх үндэстэн, овог, хэлтэн, ард түмэнд тунхаглах. Сүнсний удирдамжийн дагуу гэрчлэлээ илэрхийлэх замаар сайн мэдээг хуваалцах.
- Гэгээнтнүүдийг төгөлдөржүүлэх. Шинээр элсэгчид найзтай, дуудлагат ажилтай, мөн Бурханы үгээр тэжээгдэж байхад анхаарах замаар Сүмд өсч хөгжихөд нь туслах. Сайн мэдээний ёслолуудыг хүлээн авч, гэрээ байгуулан амласан зарлигуудаа сахин биелүүлэхэд хичээл зүтгэл гаргах, нөхөддөө үйлчлэх, ядуус болон гачигдалтай хүмүүсийг анхаарч халамжлах, Гэгээнтнүүдийн нийгмийг байгуулахад бие биендээ нөхөрсгөөр туслах.



- Нас барагсдыг гэтэлгэх. Нас барсан өвөг дээдсээ мэдэж авч, гэр бүлийн өргөмжлөлд аль болох үндэслэлтэйгээр бэлтгэхийн тулд тэдний төлөөх ариун сүмийн ёслолуудыг гүйцэтгэхэд нь гишүүдэд тусалдаг.

Сайн Мэдээг Хуваалцах

Сайн мэдээг хуваалцахыг Их Эзэн Сүмийн гишүүдээс хүсдэг. Удирдагчид өөрсдөө сайн мэдээг хуваалцахаас гадна бусад гишүүдийг хийхийг урамшуулан дэмжих ёстой. Сайн мэдээг хуваалцах зарим арга хэлбэрүүд гэвэл:

- Сайн мэдээний зарчмуудын дагуу амьдарч сайн үлгэр дууриал үзүүлэх.
- Сайн мэдээ болон тэдний амьдрал үүний авчирдаг адислалуудын талаар найз нөхөд болон

гэр бүлийнхээ гишүүдэд ярьдаг байх.

- Дүүргийн буюу бүрэн цагийн номлогчдод туслах.
- Сайн мэдээг бусдад танилцуулах үйл ажиллагаа болон хөтөлбөрүүдийг төлөвлөх явдал мөн.

Сайн мэдээг хуваалцах өөр нэг хэлбэр бол бүрэн цагийн номлолд үйлчлэхэд бэлтгэхэд нь гишүүдэд туслах явдал мөн. Удирдагчид үйлчлэлд бэлтгэхэд нь залуучуудад тусалж, хүүхдүүдээ номлолд бэлтгэхэд нь эцэг эхчүүдийг, мөн түүнчлэн тэтгэвэрт гарсан хосуудыг номлолд үйлчлэхэд нь дэмжин урамшуулж чадна. Мөн түүнчлэн өөрсдийнхөө номлолд төлөх мөнгө хуримтлуулахад нь тэд гишүүдэд зөвлөгөө өгч бас номлогчдыг санхүүгийн талаар дэмжиж болно.

Салбарын номлолын удидагч нь (дуудагдсан бол) салбарын ерөнхийлөгчийн удирдлага дор салбардахь номлолын ажлыг зохицуулна.

Гэгээнтнүүдийг Төгөлдөржүүлэх

Гэгээнтнүүдийг төгөлдөржүүлэх гэдэг нь өргөмжлөлд бэлтгэхийн тулд гишүүн бүрийг өдөр болгон сайн мэдээний дагуу амьдрахад нь урамшуулан дэмжиж, туслах явдал мөн. Гэгээнтнүүдийг төгөлдөржүүлэх нь сүнслэг хийгээд эд материаллаг талын аль алиныг хамардаг.

Сүнслэг Бэлтгэл



Сүнслэг хүч чадлаа нэмэгдүүлэхэд нь гишүүдэд хэрхэн туслахыг мэдэхийн тулд удирдагчид сүнслэг удирдамжийн төлөө байнга залбирч байх ёстой. Удирдагчид нь гишүүдэд сайн мэдээг зааж, түүний дагуу амьдрахад нь уриалснаар сүнслэг талаараа бэлтгэгдэхэд нь тэдэнд тусалж чадна. Залбирч, мацаг барьж, ариун ёслолоос хүртэж, мөн судрууд хийгээд хожмын үеийн бошиглогчдын сургаалуудыг судалснаар Их Эзэнд ойр байхад нь тэд гишүүдийг урамшуулан дэмжих ёстой. Сүмийн цуглаанууд сүнслэг байдлыг бэхжүүлдэг байхад тэд анхаарч, мөн гишүүд тус бүрт үйлчлэн хайраа харуулснаар гишүүдэд үйлчлэх боломж олгох ёстой.

Гэгээнтнүүдийг төгөлдөржүүлэх хүчин чармайлтууд хувь хүмүүс хийгээд гэр бүлүүд дээр төвлөрөх ёстой. Сүм гэр бүлүүд хийгээд өрх гэрүүдийг бэхжүүлж, дэмждэг билээ. Айл гэр бол сайн мэдээг заах болон удирдан тэргүүлэх ажлын

хамгийн чухал газар мөн. Гэр бүлийн гишүүд бие биеэ хайрлаж үйлчлэхэд удирдагчид тэднийг урамшуулан дэмжиж, эцэг эхчүүд хүүхдүүддээ сайн мэдээг зааж, гэр бүлийн үдшийг тогтмол явуулах талаар үүрэг хариуцлага хүлээдэг байхад онцгой анхаарах хэрэгтэй.

Сүмийн бүх гишүүд ариун сүмийн адислалуудыг хүлээн авахад бэлтгэх хэрэгтэй. Энэ талаар гишүүдийн хүлээх үүргийг *Гэр Бүлийн Удирдамжид* (31180) авч үзсэн байдаг. Удирдагчид ариун сүмийн тухай тэдэнд зааснаар ариун сүмийн адислалуудыг хүлээж авахад бэлтгэхэд нь гишүүдэд тусалж чадна. Гишүүд ариун сүмийн зөвшөөрлийн бичиг хүлээн авч, байнга хүчин төгөлдөр байлгахуйц зохистойгоор амьдрах, түүнчлэн боломжтой газарт, ариун сүмийн индаументууд хийгээд ариун сүмийн холбох ёслолуудыг хүлээн авахад удирдагчид тэднийг урамшуулан дэмжих ёстой. Зохистой хүн гэдэг бол усан баталгааны гэрээ мэт гэрээнүүдийг Их Эзэнтэй хийсэн, мөн эдгээр гэрээнүүдийг хичээнгүйлэн сахирын тулд хичээл зүтгэл гаргадаг хүн юм.

Бие Махбодын Хийгээд Материаллаг Бэлтгэл

Бие даах болон гэнэтийн санамсаргүй үйл явдлуудад бэлтгэлтэй байхыг тэдэнд зааснаар удирдагчид бие махбодын болон материал-

лаг хэрэгцээгээ хангахад бэлтгэлтэй байхад нь гишүүдэд тусалж чадна. Удирдагчид аравны нэгийн хууль болон мацгийн хуулийн дагуу амьдрахыг гишүүдэд зааж, нөөцөө ухаалгаар зарцуулж, өр төвихгүй байхад нь тэднийг урамшуулан дэмжиж, мөн ажиглаж, бас тэдэнд туслахын тулд гэрийн болон айлчлагч багш нарыг томилол явуулж болно.

Удирдагчид салбар дахь ядуу болон гачигдалтай хүмүүсийг судалж, тэдний төлөө халамж тавихад туслахын хамт үүнийг хийхийг салбарын гишүүдэд заах ёстой.

Гишүүд бие махбодынхоо хэрэгцээг хэрхэн хангах тухай дэлгэрэнгүй мэдээллийг *Гэр Бүлийн Удирдамжаас* үз.

Ариун Сүмийн Ёслолууд ба Гэр Бүлийн Түүх



Гишүүд ариун сүмийн ёслолуудыг өөрсдөө хүлээн авахаас гадна, өвөг

дээдсээ мэдэж, тэдний төлөө ариун сүмийн ёслолуудыг гүйцэтгэснээр нас барагсдыг гэтэлгэхэд тусалдаг. Гишүүд юуны өмнө өөрсдийн дөрвөн үеийн өвөг дээдэст анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй. Нас барагсдыг гэтэлгэхтэй холбоотой номлолуудыг удирдагчид гишүү-

дэд зааснаар ариун сүмийн ажилд зориулж нэрс өгөх, түүнчлэн боломжтой газарт нас барсан өвөг дээдсийнхээ болон бусад хүмүүсийн төлөө ариун сүмийн ёслолуудыг гүйцэтгэхийг нь урамшуулан дэмжсэнээр гишүүдэд тусалж чадна.

Пристийн Зэрэг



Пристийн зэрэг бол Бурханы хүч ба эрх мэдэл мөн. Тэрбээр үүгээр дамжуулан “үхэшгүй байдал ба мөнх амьдралыг хүмүүнд авчрах явдал” (Мосе 1:39) болох Өөрийн ажил хийгээд алдар сууг хэрэгжүүлдэг билээ. Сүмийн зохистой эрэгтэй гишүүд Түүний пристийн зэрэгтэй байхыг Есүс Христ зөвшөөрдөг билээ. Тэд пристийн зэрэгт томилогдсоноор сайн мэдээг номлох, пристийн зэргийн ёслолуудыг гүйцэтгэх, мөн ийнхүү нэрлэдгээр газар дэлхий дээрх Бурханы хаант улсад үйлчлэх гэх мэт Их Эзэний ажлыг хийх эрх мэдэлтэй болдог.

Сүмд пристийн хоёр зэрэг, тухайлбал, Мелкизедек болон Аароны зэрэг байдаг. Бошиглогч Жозеф Смитээр дамжуулан тэнгэрийн элчүүд пристийн зэргийн эрх мэдлийг газар дэлхий дээр сэргээсэн юм.

Мелкизедек Пристийн Зэрэг

Мелкизедек Пристийн Зэрэг бол илүү өндөр зэрэг. Энэ зэрэг нь Абрахамын үед амьдарч байсан агуу их дээд пристийн нэрнээс гаралтай юм (С ба Г 107:2–5-ыг үз). Пристийн энэ зэргийг атгагч ах нар Сүмд удирдах албан тушаалуудыг

атгаж, мөн сайн мэдээг номлох явдлыг удирдан чиглүүлэх хүч ба эрх мэдэлтэй байдаг. Тэд номлол, дүүрэг, салбар болон чуулгуудыг тэргүүлэхээр дуудагддаг.

Эрэгтэй хүн Мелкизедек Пристийн зэргийн албан тушаалд томилогдохын өмнө эхлээд өөрт нь олгосон Мелкизедек Пристийн зэрэгтэй байх ёстой. Дараа нь тэрээр пристийн зэргийн энэ албан тушаалд томилогддог. Эдгээр албан тушаалууд бол ахлагч, дээд прист, патриарх, далтан, түүнчлэн төлөөлөгч юм. Номлолын буюу дүүргийн пристийн зэрэгтний удирдагчид Мелкизедек Пристийн Зэргийг аргагч ах нарыг номлол буюу дүүрэг дэх ахлагч нарын чуулгуудад зохион байгуулдаг. Ахлагч нарын чуулга болгоныг ерөнхийлөгч тэргүүлдэг. Тэрээр чуулгын гишүүдэд үүргүүдийг нь зааж, чуулгын гишүүдийн хооронд ах дүүсэг ёсыг урамшуулан дэмждэг. Салбар дахь Мелкизедек Пристийн Зэрэгтэй бүх ах нар ахлагч нарын чуулгын гишүүд юм.

Ахлагч ба Ахлагч Нарын Чуулгын Ерөнхийлөгчийн Зөвлөл

Ахлагчид нь зааж, ухуулж, усаар баталж мөн Сүмийг ажиглаж байх ёстой. Ахлагчид нь Аароны Пристийн Зэргийн албан тушаалуудын эрх мэдэл, үүрэг хариуцлагуудтай байдгаас гадна Ариун сүнсний бэлэг өгч, өвчтөнд үйлчлэл үзүүлэх

болон бусад ёслолуудыг гүйцэтгэж болно (*Гэр Бүлийн Удирдамж* дахь “Пристийн Зэргийн Ёслолууд ба Адислалууд”-ыг үз.) Өөрсдийн Пристийн Зэрэгтний удирдагчдаас эрх мэдэл олгосон үед ахлагчид, эрх мэдэл бүхий дээд прист байхгүй үед Сүмийн цуглаануудыг тэргүүлж болно. (С ба Г 20:20:42-; 107:11-ийг үз.)

Мелкизедек Пристийн зэрэгтэй, зохистой эрэгтэйчүүд салбарт байгаа үед, номлолын буюу дүүргийн ерөнхийлөгчийн зөвлөл Сүнсний удирдамжийн дагуу ахлагч нарын чуулгыг салбарт зохион байгуулж, чуулгын гишүүдийн дундаас чуулгын ерөнхийлөгчийг дуудан, онцгойлон адислаж болно. Салбар дахь ахлагчдын тоо өсөхөд, номлолын ерөнхийлөгчийн зөвлөл ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчийн хоёр зөвлөхийг дуудаж, онцгойлон адислаж болно. Ахлагч нарын чуулга бүр нь 96 хүртэл гишүүнээс бүрдэж болно. Чуулга нь эцгүүд болон чуулгын бусад гишүүдэд үлгэр дууриал үзүүлж туслан чиглэл өгнө.

Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч нь дүүргийн буюу номлолын ерөнхийлөгчийн удирдлага чиглүүллийн дор үйлчилж, түүнд ажлаа тайлагнана. Түүнчлэн чуулгын ерөнхийлөгч нь салбарын пристийн зэрэгтний гүйцэтгэх хорооны гишүүн болон салбарын зөвлөлийн гишүүний хувьд салбарын

удирдлага чиглүүлэл дор ажилладаг. Чуулгын ерөнхийлөгч нь салбар дахь чуулгын гишүүдийг тэргүүлж, тэдэнд үлгэр дууриал үзүүлдэг. Сүм салбарын бүх гишүүдтэй идэвхтэй хэлхээ холбоотой байхад чухалчлан анхаарч, тэрээр салбарын ерөнхийлөгчийн хамт гэрийн багшийн ажлыг удирдан зохион байгуулж ажиллана.

Чуулгын ерөнхийлөгч сайн мэдээ болон Мелкизедек Пристийн Зэргийн үүрэг хариуцлагуудыг чуулгын гишүүдэд заадаг (С ба Г 107:89-ийг үз). Тэрээр тэднийг, ялангуяа нөхөр болон эцгийнхээ үүрэг хариуцлагуудад баяр хөөр ба даруу байдлаар үйлчлэхэд урамшуулан дэмждэг. Тэрээр тэдэнд пристийн зэргийн ёслолуудыг хэрхэн гүйцэтгэхийг зааж, чуулгад ах дүүсэг ёсыг бий болгоход гишүүдэд туслах үйлчлэлийн төслүүд хийгээд үйл ажиллагаануудыг төлөвлөдөг. Тэрээр чуулгын гишүүдийн сүнслэг хийгээд эд материаллаг сайн сайхан байдлын төлөө хариуцлага хүлээдэг.

Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч нь Мелкизедек Пристийн Зэрэгтнүүд болон Аароны Пристийн зэрэгтэй насанд хүрэгчдийг (19 ба түүнээс дээш насны) гэрийн багшаар томилж, мөн салбарын ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр Аароны Пристийн зэрэг дэх багш нар, пристийн зэрэгтэй залуу эрэгтэйчүүдийг гэрийн багшаар то-

милон ажиллуулна. Гэрийн багш нар нь хүмүүстэй ганцаарчилсан ярилцлага хийх үед хоёр хоёроороо хамтрагч хос болон томилогддог. Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч нь салбарын ерөнхийлөгчийн зөвшөөрснөөр гэр бүлийн хосын айлчлал зайлшгүй шаардлагатай байгаа тохиолдолд Мелкизедек Пристийн зэрэгтэй хүний эхнэрийг нөхөртэй нь хамтрагч болгон томилж болно.

Чуулгын ерөнхийлөгч нь гэрийн багшлалтын зорилгуудыг (хуудас 6-7-г үз) чуулгын гишүүдэд зааж, эдгээр зорилгуудыг хэрэгжүүлэхэд нь тэднийг сүнслэг байдлын хувьд урамшуулан дэмжинэ. Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн нэг гишүүн гэрийн багш нарын айлчлалын талаар илтгэл мэдээлэл хүлээж авах хийгээд гишүүдийн эрэлт хэрэгцээний талаар мэдэж авахын тулд тэдэнтэй тогтмол ярилцлага хийдэг.

Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч гэрийн багшлалтад хяналт тавьж, гэрийн багш нарын айлчлалт болон гишүүдийн эрэлт хэрэгцээ, мөн гэрийн багшийн айлчлалаас мэдэж авсан санаа тавих асуудлуудын талаар салбарын ерөнхийлөгчид мэдээлж байна.

Чуулгын ерөнхийлөгч чуулгын гишүүдийг Сүмийн цуглаанууд болон үйл ажиллагаануудад оролцох, мөн үйлчлэл үзүүлэхэд нь урамшуулан дэмжинэ. Тэрээр томилогдоогүй

эрэгтэйчүүд болон 18-аас дээш насны Аароны Пристийн зэрэгтнүүдийг Мелкизедек Пристийн Зэрэг ба ариун сүмийн ёслолуудыг хүлээн авахад бэлтгэхэд нь тусалдаг. Эдгээр зүйлд гэрийн багш нар тусалдаг хэдий ч, ихэвчлэн ерөнхийлөгч нь чуулгынхаа гишүүн бүрд тухайлан үйлчлэх шаардлагатай.

Дээд Прист, Патриарх, Дал ба Төлөөлөгч

Дээд Прист, Патриарх, Дал ба Төлөөлөгчийн албан тушаалуудын тухай мэдээллийг *Gospel Principles*, бүлэг 14-өөс үз.

Гэрийн Багшлалт



Пристийн зэргийг атгагч ах нар бол гэрийн багш нар бөгөөд салбарын гишүүдийг ажиглаж, хүчтэй болгоход нь пристийн зэрэгтний удирдагчдад тухлааар дуудагдсан байдаг. Диконуудаас бусад Мелкизедек Пристийн Зэрэг, мөн Аароны Пристийн Зэргийг атгагч эрэгтэйчүүд гэрийн багшаар үйлчилж болно.

Гэрийн багш нар гишүүдээр тогтмол айлчлан очиж, тэдэнд хайрыг үзүүлж, сайн мэдээг зааж, Христэд ирэхэд тэднийг урьдаг. Гэрийн багш нар эцгүүдийг залбирч, гэр бүлийнхнийхээ төлөө зохих ёсоор анхаарч халамжлахыг нь урамшуулан дэмжих ёстой. Гишүүдийг өвчлөх, гэрт нь хүн нас барах, ганцаардах, ажилгүй болох, мөн бусад өвөрмөц хэрэгцээ шаардлага тохиолдсон үед нь гэрийн багш нар тусалдаг. (С ба Г 20:51, 53, 59-ийг үз).

Гэрийн багш нар томилогдсон гэр бүлүүдэд айлчлах үедээ Их Эзэнийг, салбарын ерөнхийлөгчийг, түүнчлэн чуулгынхаа ерөнхийлөгчийг төлөөлдөг. Тэд гэр бүлийн гишүүдийн сонирхол хийгээд эрэлт хэрэгцээг мэдэж, мөн эдгээрийг жинхэнэ ёсоор сонирдог. Сүнсний өдөөлтийн дор гэрийн багш нар сайн мэдээг зааж, өөрсдийнхөө айлчлан очсон хувь хүмүүс хийгээд гэр бүлийн гишүүдийн итгэлийг хөгжүүлж, бэхжүүлэхийг эрэлхийлдэг билээ. Боломжтой бол гэрийн багш болон хамтрагчтай байх ёстой.

Гэрийн багш нар:

- Томилогдсон гишүүнтэйгээ идэвхтэй хэлхээ холбоотой байх.
- Эцгийг гэр бүлийн тэргүүнийх нь хувьд (ээж, эсвэл эцэг нь байхгүй ганц бие гишүүн байгаа айлд) хүлээн зөвшөөрч, үгэшгүй байдал ба мөнхийн амьдрал уруу хийх аянд гэр бүлийнхээ

гишүүдийг удирдахад нь түүнд тусалдаг.

- Судруудын хэсгээс эсвэл *Тэргүүн Зөвлөлийн Захиас Бичиг, Лиакхона* буюу *Ensign*-д агуулагдсан амьд бошиглогчдын үгсээс хуваалцах замаар Есүс Христэд итгэх итгэлтэй болоход нь гишүүдэд тусална.
- Айлчилж очсон хүмүүстэйгээ хамт залбирч, мөн адисла.
- Цуглаанууд, чуулга, салбарын үйл ажиллагаанууд, түүнчлэн тусгай төслүүдийн талаар уг гэр бүлд мэдээлж, тэдгээрт оролцоход нь тэдэнд тусалдаг.
- Гишүүдийн өсөлтийн талаар ахлагч нарын чуулгын ерөнхийлөгчид (хэрэв салбарын ерөнхийлөгчид ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч байхгүй бол салбарын ерөнхийлөгчид).
- Сайн мэдээний бүх чухал ёслолуудыг хүлээн авах хийгээд гэрээнүүдэд нэгдэн ороход нь гэр бүлийн гишүүдийг урамшуулан дэмждэг.
- Номлолын ажил, гэр бүлийн түүхийн болон ариун сүмийн ажил хийхэд нь гишүүдийг урамшуулан дэмждэг.

Ёслолууд ба Адислалууд

Пристийн зэргийн ёслолууд бол Их Эзэнээр илчлэгдэж мөн пристийн

зэргийн эрх мэдлээр гүйцэтгэгддэг ариун нандин зан үйл юм.

Пристийн зэргийн адислалуудыг эдгээх, тайвшруулах болон урам зориг хайрлахад өгдөг. Усаар батлах болон ариун ёслолыг адислаж түгээх нь пристийн зэргийн ёслолуудын жишээ мөн. Зарим ёслолуудыг Аароны Пристийн зэрэгтэй ах нар гүйцэтгэж болох хэдий ч, олонхи ёслолуудыг Мелкизедек Пристийн зэрэгтэй ах нар гүйцэтгэдэг (энэ удирдамжийн “Аароны Пристийн Зэрэг”, мөн *Гэр бүлийн Удирдамжийг* үз). Салбарын ерөнхийлөгчид болон ахлагч нарын чуулганы ерөнхийлөгчид ёслолуудыг хэрхэн гүйцэтгэхийг ах нарт зааж сургах ёстой. Эдгээр удирдагчид ёслолуудыг гэр бүлийнхээ гишүүдэд зориулж бэлтгэх болон гүйцэтгэхэд зохистой байхад нь эцгүүдэд туслах ёстой. Ёслолууд ба адислалуудыг гүйцэтгэгч ах нар сайн мэдээний зарчмуудын амьдарч, Ариун Сүнсээр удирдагдаж байхын төлөө хичээл зүтгэл гаргах замаар өөрсдийгөө бэлтгэх ёстой. Тэд ёслол бүрийг гүнээ хүндэтгэсэн байдалд гүйцэтгэнэ. Ёслол бүрийг гүйцэтгэхдээ:

1. Есүс Христийн нэрээр.
2. Пристийн зэргийн эрх мэдлээр.
3. Тогтсон үг хэллэг хийгээд ариулсан тос мэт зайлшгүй шаардлагатай дэг журмыг баримтална.
4. Хэрэв шаардлагатай бол зохих түлхүүрүүдийг атгадаг пристийн

зэргийн холбогдох удирдагчаас зөвшөөрөлтэйгөөр гүйцэтгэгдэх ёстой. *Пристийн зэрэгтний удирдагчийн зөвшөөрөл шаардагдах ёслолууд гэвэл хүүхдэд нэр өгөх болон адислах, усан баталгаа ба гишүүний баталгаа гүйцэтгэх, пристийн зэрэг олгох ба пристийн зэргийн албан тушаалд томилох, ариун ёслолыг адислаж түгээх болон булшийг онцгойлон адислах болно.*

Тусгай ёслолууд болон адисла-
луудын тухай мэдээллийг Гэр
Бүлийн Удирдамжаас үз.

Аароны Пристийн Зэрэг



Аароны Пристийн Зэрэг бол Мелкизедек Пристийн Зэрэг буюу илүү дээд зэргийн хавсралт юм (С ба Г 107:14). Үүнийг Мосегийн дүү Аароны нэрээр нэрлэсэн байна, учир нь энэ зэргийг түүнд болон түүний хойч үеийнхэнд олгодог байжээ. Аароны Пристийн зэргийг атгагч ах нар пристийн зэргийн зарим ёслолуудыг гүцэтгэх эрх мэдэлтэй байдаг. Пристүүд нь усан баталгаа хийж, ариун ёслолыг адислан, мөн пристүүд, багш нар

болон диконуудыг томилж болно. Пристүүд болон багш нар ариун ёслолыг бэлтгэж болно. Пристүүд, багш нар, мөн диконууд ариун ёслолыг түгээж болно. (С ба Г 107:13–14, 20-ийг үз.)

Аароны Пристийн зэргийг хүнд олгоход тэрээр пристийн энэ зэргийн албан тушаалд томилогддог. Албан тушаалууд нь дикон, багш, прист юм. Сүнсний удирдамжаар түүнчлэн Аароны пристийн зэрэгтнүүдийн тооноос хамааран салбар дахь Аароны Пристийн зэрэгтний ерөнхийлөгч болох салбарын ерөнхийлөгч нь адил албан тушаалтай ах нарыг диконы (12–13 нас), багш нарын (14–15 нас), пристийн (16–18 нас) чуулгуудад хуваан зохион байгуулдаг.

Аароны Пристийн зэрэгтний ерөнхийлөн тэргүүлэх түлхүүрүүдийг атгадаг салбарын ерөнхийлөгч нь салбар дахь Аароны Пристийн зэрэгтний ерөнхийлөгч байдаг. Тэрээр пристийн чуулгын ерөнхийлөгч бөгөөд зохистой хоёр пристийг пристийн чуулгад үйлчлэх туслагчдаараа дуудаж болно. Тэрээр зохистой багш болон мөн зохистой диконыг багш нарын болон диконы чуулгад ерөнхийлөгчөөр үйлчлүүлэхээр тус тус дуудаж болно. Салбарын ерөнхийлөгч өөрөө буюу томилогдсон нэг зөвлөх нь эдгээр чуулгуудын ерөнхийлөгчийн зөвлөлийг бүрдүүлэхийн тулд багш нарын болон диконы

чуулгуудын ерөнхийлөгчдөд хоёр туслахыг дуудаж болно. Чуулгууд хангалттай тооны залуу эрэгтэйчүүдтэй болсон үед салбарын ерөнхийлөгчийн зөвлөлийн нэг гишүүн чуулга тус бүрд нэг залуу эрэгтэйг чуулгын нарийн бичгийн даргаар үйлчлүүлэхээр дуудаж болно.

Салбарын ерөнхийлөгч пристийн чуулга дахь өөрийн туслахууд хийгээд багш нарын болон диконы чуулгын ерөнхийлөгчдийг онцгойлон адислана. Салбарын ерөнхийлөгчийн зөвлөлийн нэг гишүүн чуулгуудын ерөнхийлөгчийн зөвлөлийн зөвлөхүүд болон нарийн бичгийн дарга нарыг онцгойлон адислана.

Пристийн зэрэгтний цуглааны нээлтийн ажиллагааны дагуу Аароны Пристийн зэрэгтнүүд нь Мелкизедек Пристийн Зэрэгтнүүдээс тусдаа салбарын ерөнхийлөгчийн удирдлаган дор цуглаанаа явуулна.

Салбарын ерөнхийлөгч Аароны Пристийн зэрэгтний чуулгуудыг зохион байгуулахдаа Сүнсний удирдамжаар Мелкизедек Пристийн зэрэгтэй буюу Аароны Пристийн Зэрэг дэх пристийн албан тушаалтай хүнийг Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгчөөр үйлчлүүлэхээр дуудаж, онцгойлон адисладаг. Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхийлөгч чуулгын гишүүн бүрийг Есүс Христэд итгэх итгэлээ бэхжүүлж, дахин сэргэсэн сайн

мэдээний зарчмуудад нийцүүлэн амьдрах тухай ойлголт хийгээд шийдвэр төгс байдлаа өсгөн нэмэгдүүлэхэд нь туслахын тулд салбарын ерөнхийлөгчийн зөвлөл болон Аароны Пристийн Зэрэгтний чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлтэй хамтран ажиллана.

Аароны Пристийн Зэрэгтний зорилго нь пристийн энэ зэрэгт томилогдсон хүн болгонд туслах явдал мөн, үүнд:

- Есүс Христийн сайн мэдээнд хөрвүүлэгдэж, сайн мэдээний сургаалуудын дагуу амьдрахад нь.
- Пристийн зэрэгтний дуудлагуудаа үнэнчээр үйлчилж, пристийн зэрэгтний албан тушаал бүрийн үүрэг хариуцлагуудыг биелүүлэхэд нь.
- Утга учир бүхий үйлчлэл үзүүлэх.
- Мелкизедек Пристийн Зэрэг хийгээд ариун сүмийн ёслолууд хүлээн авахын тулд бэлтгэн, зохистойгоор амьдрахад нь.
- Бүрэн цагийн номлолд хүндэтгэлтэйгээр үйлчлэхэд бэлтгэхэд нь.
- Аль болохоор ахиу боловсрол эзэмшихийн хамт зохистой эр нөхөр, эцэг болоход нь бэлтгэх.
- Эмэгтэйчүүд, охид, хүүхдүүдэд зохих ёсоор хүндэтгэл үзүүлэхэд нь.

Эдгээр зорилгуудыг хэрэгжүүлэхэд туслах чуулгын цуглаанууд, үйлчлэх төслүүд болон үйл ажиллагаануудыг төлөвлөхөд салбарын ерөнхийлөгч Аароны Пристийн Зэрэгтний чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлтэй хамтран ажиллана. Үйл ажиллагаанууд нь залуу эрэгтэйчүүд анд найз нар болж, үйлчлэл үзүүлэн, адил итгэл үнэмшил хийгээд жишгүүдийг хуваалцаж чадах бусад хүмүүстэй ур чадвараа хөгжүүлж чадахуйц тийм цогц орчныг хангасан байх ёстой.

Аароны Пристийн Зэрэгтний чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл хийгээд Залуу Эмэгтэйчүүдийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөл нь Аароны Пристийн Зэрэгтний болон Залуу Эмэгтэйчүүдийн насанд хүрсэн удирдагчидтай хамтран ажиллаж, салбарын ерөнхийлөгчийн хяналтын дор Аароны Пристийн Зэрэгтний болон Залуу Эмэгтэйчүүдийн хамтарсан үйл ажиллагаануудыг төлөвлөж болно. Хамтарсан үйл ажиллагаануудыг Харилцан Ажиллагаа гэдэг.

Дикон

Хамгийн бага нь 12 настай, усан баталгаа хийлгэж, гишүүнээр батлагдсан зохистой залуу эрэгтэй диконоор томилогдож болно. Диконууд ихэвчлэн ариун ёслолыг түгээх, Сүмийн барилгууд хийгээд газар, гачигдалтай хүмүүст анхаарал халамж тавихад туслах,

мацгийн өргөл цуглуулах мэт тусгай үүрэг даалгавруудыг биелүүлэх үүрэгтэй байдаг.

Диконы чуулга нь 12 хүртэл диконоос бүрдсэн байж болно (С ба Г 107:85-ыг үз).

Багш

Хамгийн бага нь 14 настай, зохистой залуу эрэгтэй багшаар томилогдож болно. Диконуудын бүх эрх мэдэл, үүрэг хариуцлагуудаас гадна багш нар ариун ёслолыг бэлтгэж, гэрийн багшаар үйлчилдэг.

Багш нарын чуулга нь 24 хүртэл багшаас бүрдсэн байж болно (С ба Г 107:86-г үз).

Прист

Хамгийн бага нь 16 настай зохистой ах нар пристээр томилогдож болно. Ихэвчлэн насанд хүрсэн эрэгтэй шинэ гишүүд ахлагчаар томилогдохын тулд хангалттай туршлагатай болох хүртлээ пристээр томилогдсон байдаг.

Дикон болон багш нарын бүх эрх мэдэл, үүрэг хариуцлагуудаас гадна, пристүүд усаар баталж, ариун ёслол адислаж, мөн Мелкизедек Пристийн зэрэгтэн байхгүй үед цуглаануудыг хөтлөн явуулж болно (С ба Г 20:46–51).

Пристийн чуулга нь 48 хүртэл пристээс бүрдсэн байж болно (С ба Г 107:87–88-ыг үз).

Хавсралт Байгууллагууд



Салбарт пристийн зэрэгтний байгууллага хамгийн түрүүнд байгуулагддаг. Гишгүүдийн тоо өсч, удирдагчид хийгээд цуглааны байрууд байгаа тохиолдолд салбарын ерөнхийлөгч пристийн зэрэгтний байгууллагад шаардлагатай гэж өөрийн үзсэн хавсралт байгууллагуудыг зохион байгуулж болно. Хавсралт байгууллагууд нь Нийгмийн Халамжийн Бүлэг, Залуу Эрэгтэйчүүд, Залуу Эмэгтэйчүүд, Хүүхдийн Хэсэг түүнчлэн Ням Гарагийн Сургууль юм.

Салбар хангалттай тооны эмэгтэйчүүд, залуу эмэгтэйчүүд, хүүхдүүдтэй болж, тэднийг бие даасан хавсралт хэсгүүдэд хуваатал, тэд

хичээл хийхийн тулд Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн удирдлага дор хамтдаа цуглана.

Нийгмийн Халамжийн Бүлэг

Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлээ төлөвшүүлэхэд нь насанд хүрсэн эгч нарыг (18 ба түүнээс дээш насны) урамшуулан дэмжих замаар Нийгмийн Халамжийн Бүлэг нь пристийн зэрэгтний удирдагчдад тусалдаг. Нийгмийн Халамжийн Бүлэг нь Есүс Христэд ирж, Ариун Сүнсний удирдамжийг хүлээн авахуйцаар зохистой амьдрахад нь эмэгтэйчүүд хийгээд гэр бүлүүдэд тусалдаг. Нийгмийн

Халамжийн Бүлгийн эгч нар сайн мэдээний номлолуудыг зааж, судлан, энэрлийн үйлчлэл үзүүлж, гэр ахуйн ур чадвараа хөгжүүлэн, гэр бүлийн харилцааг бэхжүүлж, эгч болгонд үйлчлэл үзүүлж, урамшуулан дэмждэг.

Салбар доод тал нь хоёр эмэгтэй гишүүнтэй байгаа тохиолдолд салбарын ерөнхийлөгч Нийгмийн Халамжийн бүлгийг зохион байгуулж болно. Салбарын ерөнхийлөгчийн удирдлага дор Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч нь:

- Ням гарагуудад эрэгтэйчүүд болон залуу эрэгтэйчүүд пристийн ээрэгтний цуглаан хийж байгаа үед насанд хүрсэн эмэгтэйчүүдийн (18 ба түүнээс дээш насны) хичээлийг удирдах буюу хөтлөн явуулдаг.
- Эмэгтэйчүүд, залуу эмэгтэйчүүд түүнчлэн хүүхдүүдийн эрэлт хэрэгцээ ба үйл ажиллагааны талаар салбарын ерөнхийлөгчид зөвлөгөө өгч, түүнтэй хамтран ажилладаг.
- Гачигдалтай хүмүүсийг олж тогтоон, анхаарал халамж тавихад нь салбарын ерөнхийлөгчид тусалдаг.

Залуу Эрэгтэйчүүд

Тус удирдамжийн 8–10-р хуудсанд дахь “Аароны Пристийн Зэрэг”-ийг үз.

Залуу Эмэгтэйчүүд



Салбарын ерөнхийлөгчийн зөвлөл нь 12-оос 18 насны залуу эрэгтэйчүүдийн төлөө хариуцлага хүлээдгийн нэгэн адил мөн залуу эмэгтэйчүүдийн төлөө хариуцлага хүлээдэг.

Залуу эмэгтэйчүүдийн байгууллага нь охидыг (12-оос 17 насны) Есүс Христийн сайн мэдээнд хөрвүүлэгдэх, эцэг эхээ хүндлэх, ариун сүмийн гэрээнүүд байгуулж сахих, түүнчлэн зохистой эхнэр хийгээд эх болох, мөн үйлчлэл үзүүлэхэд нь тусалдаг. Залуу эмэгтэйчүүдэд Ням гарагийн цуглаанууд болон ажлын өдрүүдэд зохиогддог үйл ажиллагануудад сайн мэдээг заалгадаг.

Салбарт хангалттай тооны залуу эмэгтэйчүүд байгааг салбарын ерөнхийлөгч тогтоосон үед 12-оос 17 насны залуу эмэгтэйчүүд Нийгмийн Халамжийн Бүлгээс тусдаа цуглаанаа хийж болно. Салбарын ерөнхийлөгч тэднийг Бихайв (12–13 нас), Миа Мэйд (14–15 нас), Лаурел (16–17 нас) ангиудад зохион байгуулна. Тэрээр анги

болгонд зохистой залуу эмэгтэйг ангийн ерөнхийлөгчөөр дуудаж, онцгойлон адислаж болно. Ангид хангалттай тооны залуу эмэгтэйчүүд байгаа тохиолдолд салбарын ерөнхийлөгчийн зөвлөлийн нэг гишүүн эдгээр ерөнхийлөгч тус бүрд өөр хоёр залуу эмэгтэйг зөвлөхөөр, мөн түүнчлэн ангийн нарийн бичгийн даргаар дуудаж, онцгойлон адислаж болно.

Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөл нь Есүс Христэд итгэх залуу эмэгтэй бүрийн итгэлийг бэхжүүлэх, дахин сэргэсэн сайн мэдээний зарчмуудад нийцүүлэн амьдрах тухай ойлголт, энэ талаарх шийдвэр төгс байдлыг дээшлүүлэхийн тулд салбарын ерөнхийлөгчийн зөвлөл хийгээд Залуу Эмэгтэйчүүдийн (охидын) ерөнхийлөгчийн зөвлөлүүдтэй салбарын ерөнхийлөгчийн удирдлагын дор хамтран ажиллана. Ням гарагт сайн мэдээг заах болон долоо хоногийн ажлын өдрүүд дэх цогц үйл ажиллагаанууд нь эдгээр зорилгыг хэрэгжүүлэхэд тусалдаг.

Залуу эмэгтэйчүүдийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөл хийгээд Аароны Пристийн Зэрэгтний чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл нь Залуу Эмэгтэйчүүд болон Аароны Пристийн Зэрэгтний насанд хүрсэн удирдагчидтай хамтран ажиллаж салбарын ерөнхийлөгчийн хяналтан дор Залуу Эмэгтэйчүүд хийгээд Аароны Пристийн

Зэрэгтний хамтарсан үйл ажиллагаануудыг төлөвлөж болно. Хамтарсан үйл ажиллагаануудыг Харилцан Ажиллагаа гэдэг.



Хүүхдийн Хэсэг

Хүүхдийн хэсэг нь Есүс Христийн сайн мэдээг хүүхдүүдэд (3-аас 11 нас хүртэлх) зааж, үүний дагуу амьдарч сурахад нь тэдэнд тусалдаг. Хүүхдийн Хэсэгт хүүхдүүд баяр хөөртэй байж, Аврагчийн хайрыг мэдрэн, сайн мэдээний авчрах баяр хөөрийг мэдрдэг.

Хүүхдийн Хэсгийн сэдэв нь “Та нарын бүх хүүхдүүд Их Эзэний тухай заалгах ёстой; тийнхүү та нарын хүүхдүүдийн амар амгалан агуу их байх болно” (3 Нифай 22:13). Хүүхдийн Хэсэг нь хүүхдүүдийг судруудаас сурах, залбирах болон Аврагчийн үлгэр жишээг дагахыг нь урамшуулан дэмжих замаар Сүмийн зорилгыг хэрэгжүүлэхэд нь пристийн зэрэгтний удирдагчдад тусалдаг. Хүүхдийн Хэсгийн зорилго нь:

- Тэд бол Бурханы хүүхдүүд, мөн Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр тэдэнд хайртай гэдгийг хүүхдүүдэд заах
- Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрыг хайрлаж сурахад нь хүүхдүүдэд туслах
- Усан баталгаа хийлгэх, Ариун Сүнс хүлээж авах, түүнчлэн усан баталгаагаар хүлээсэн гэрээнүүд хийгээд амлалтуудаа биелүүлэхэд бэлтгэхэд нь хүүхдүүдэд туслах
- Сайн мэдээний төлөвлөгөөг ойлгох ойлголтдоо өсч хөгжих, түүнчлэн сайн мэдээний зарчмуудын дагуу амьдрах боломжоор хангахад нь хүүхдүүдэд туслах
- Пристийн зэрэг хүлээн авахад бэлтгэх болон бусдыг адислаж, тэдэнд үйлчлэхэд пристийн зэргийг ашиглахын тулд зохистой байхад нь хөвгүүдэд туслах
- Зохистой эмэгтэйчүүд болоход бэлтгэх, пристийн зэргийн хийгээд ариун сүмийн адислалуудыг ойлгох, түүнчлэн бусдад үйлчлэхэд нь охидод туслах явдал мөн.

Пристийн Зэрэгтний болон Хүүхдийн Хэсгийн удирдагчид нь эцэг эхчүүд Сүнсний эрэлхийлж, түүний удирдамж дагуу хүүхдүүд дээ Есүс Христийн сайн мэдээг заахад тусалдаг. Хүүхдийн Хэсэг дэх

хүүхэд болгонд, ялангуяа сайн мэдээний дагуу амьдрахад нь хүчтэй дэмжлэг тусалцаа үгүйлэгдэж байгаа айлын хүүхдүүдэд багш нар, удирдагчдын хайр халамж шаардлагатай.

Хүүхдийн тоо хангалттай олон байгаа тохиолдолд тэд Ням гарагийн Сургууль, Нийгмийн Халамжийн Бүлгийн болон Залуу Эмэгтэйчүүдийн цагийн үеэр эмэгтэйчүүд болон залуу эмэгтэйчүүдээс тусдаа цуглаж хичээл болон хуваалцах цагийг хийдэг. Салбарууд нь зарим үед Ням гарагаас өөр өдөр Хүүхдийн Хэсгийн насны хүүхдүүдэд зориулсан арга хэмжээ зохион байгуулж болно. Хуваалцах цаг хийгээд ажлын өдрүүд дэх үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй зааврыг пристийн зэрэгтний удирдагчдаар дамжуулан авч болно.

Ням Гарагийн Сургууль

Ням гарагийн Сургууль нь Ням гарагийн цуглаануудад сүнслэг өсөлт, заавраар хангах замаар Есүс Христийн сайн мэдээг судалж, сайн мэдээний зарчмуудын дагуу амьдрахад нь 12 ба түүнээс дээш насны гишүүд болон сонирхогчдод тусалдаг. Ням Гарагийн Сургуулийн багш нар нь:

- Судруудыг судлах
- Зарлигуудыг дуулгавартай дагах
- Сайн мэдээний зайлшгүй шаардлагатай ёслолууд хийгээд

эдгээртэй холбоотой гэрээнүүдийг хүлээн авахад нь гишүүдийг урамшуулан дэмждэг.

Ням Гарагийн Сургуулийн ерөнхийлөгчийн зөвлөл Ням Гарагийн Сургуульд хяналт тавина. Ерөнхийлөгч нь чадавхитай багш нарыг салбарын ерөнхийлөгчид зөвлөмж болгодог. Салбарын ерөн-

хийлөгчийн зөвлөл Ням Гарагийн Сургуулийн ангиудад заах багш нарыг дуудаж, онцгойлон адислана. Залуучууд болон насанд хүрэгчдийн тоо цөөхөн байгаа үед тэд хамтдаа цуглаж болох хэдий ч, залуучууд, насанд хүрэгчдийн тоо нэмэгдсэн үед тэд тусдаа хичээллэхээр цуглаанаа хийж болно.



Сургалтын Хөтөлбөр ба Багшийн Хөгжил



Сургалтын Хөтөлбөр

Сүм пристийн зэрэгтний чуулга, хавсралт байгууллагуудын сургалтын хөтөлбөрийн материалуудаар хангадаг. Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөл жил тутам хэрэглэх сургалтын материалуудын тухай заавраар хангадаг. Заавруудыг Сүмийн хангамжийн буюу үйлчилгээний төвөөс жил бүр хүргүүлдэг. Пристийн зэрэгтний удирдагчдаар дамжуулан олж авч болох хэвлэн гаргасан *Пристийн Зэргийн ба Хавсралт Байгууллагуудын Удирдагчдад Зориулсан Сургалтын Хөтөлбөрийн Мэдээлэл* (36363 363) нь Сүмийн сургалтын хөтөл-

бөрийн тоймыг агуулдаг. Удирдагчид хийгээд багш нар зөвхөн Сүмээс батлан гаргасан сургалтын материалуудыг ашиглахыг дэмжигдэж Сүмийн бус материалуудыг ашиглахаас зайлсхийх ёстой.

Тэргүүн Зөвлөлийн Захиас Бичиг, Айчллагч Багшийн Захиас Бичгүүд, түүнчлэн Лиахонагийн эх сурвалжууд нь сургалтын хөтөлбөрийн гарын авлагууд дахь хичээлүүдийг шинэчлэн баяжуулах материалаар хангадаг. Эдгээр материалууд хэвлэгдсэнээс гадна Сүмийн Интернетийн албан ёсны www.lds.org сүлжээнд электрон

хэлбэрээр байгаа болно. *Лиакона* байдаг газарт салбар дахь гэр бүл болгон захиалах ёстой.

Багшийн Хөгжил

Эцэг эхчүүд, удирдагчид хийгээд багш нар Есүс Христийн сайн мэдээг заах ариун үүрэг хариуцлагатай. Бусад хүмүүс өөрсдийн хүчин чармайлтаар дамжуулан өдөр тутмынхаа амьдралд сайн мэдээг хэрхэн хэрэглэхийг сурч болно.

“Хаант улсын номлолыг та нар бие биендээ заах зарлигийг би та нарт өгч байна. Та нар хичээнгүйлэн

заагтун мөн миний нигүүлсэл та нарт байх болно” хэмээн Их Эзэн хэлжээ (С ба Г 88:77-78).

Салбарын ерөнхийлөгчийн зөвлөл салбар дахь сургалтын чанарын төлөө харицлага хүлээдэг. Салбар хангалттай тооны хүчтэй гишүүдтэй болсон үед, ерөнхийлөгчийн зөвлөл нэг ах буюу эгчийг салбарын багшийн хөгжлийн зохицуулагчаар үйлчлүүлэхээр дуудна.

Сургаалт болон багшийн хөгжлийн асуудлаар дэлгэрэнгүй мэдээллийг *Заах Удирдамжаас* үз.





Аврагчийн Үлгэр Дууриал

Бидний Аврагч, Есүс Христ Сүмд болон гэр орондоо дагаж мөрдөх төгс үлгэр дууриаллыг гишүүд хийгээд удирдагчдад үзүүлсэн билээ. Тэрээр Өөрийн Эцэгт хайртай байсан, мөн Өөрийнхөө үйлчилдэг хүмүүст хайртай байсан. Тэрээр бусдад үйлчлэхийн төлөө, хавчигдагсдыг өргөж, гутарч цөхрөгсдөд итгэл найдвар өгөхийн төлөө амьдарч байлаа.

Есүс Өөрийн дуудлагыг ойлгож, түүнийг хэрэгжүүлэхийн төлөө залбиралтай, хичээнгүй зүтгэлтэй байлаа. Тэрээр ямагт Эцэгийнхээ хүсэл зоригийг хэрэгжүүлж, мөн

Түүнд алдар сууг өргөн, Өөрийнхөө төлөө юуг ч эрэлхийлээгүй билээ. Тэрээр хүмүүн төрөлхтний төлөө бүхнээ золиосолж, бүх хүмүүсийн нүгэл хилэнцийг цагаатгахын төлөө загалмай дээр амиа өгсөн юм.

Удирдагчид Аврагчийн үлгэр жишээг дагахын хэрээр, Тэрээр Өөрийнхөө ажлыг хийх тэдний чадварыг дээшлүүлэх болно. Тэрээр тэдний хэлэх, хийх ёстой зүйлийг мэдүүлэхийн тулд тэднийг сүнслэг байдлаар урамшуулан дэмжих болно (С ба Г 100:6-г үз). Удирдагчид Бурханы хаант улсыг байгуулахад жинхэнэ ёсоор Түүний нөхөр үйлчлэгчид болж

чадна. Тэд судруудаас суралцагчид болж, сайн мэдээний номлол хийгээд зарчмуудаас сурч, өөрсдийнхөө үйлчилж байгаа хүмүүст тэдгээрийг заахад хүчин чармайлтаа дайчлах болно.

Удирдагчдын Зан Төлөвийн Шинжүүд

Итгэл

Аврагч мөнх бус үйлчлэлийнхээ үед Өөрийн шавь нараас итгэлтэй байхыг ихэд хүсэн шаарддаг байлаа (Матай 17:14–21; Лух 8:22–25-ыг үз). Сүмийн удирдагчид Есүс Христ бол бидний Аврагч бөгөөд Гэтэлгэгч гэдэгт итгэдэг байх ёстой. Тэд энэхүү итгэлээ залбирал, судруудыг судлах, дуулгавартай байдал ба наманчлалаар дамжуулан хөгжүүлдэг. Бид итгэлийн үрийг тордон тэтгэхийн хэрээр энэ үр бидний дотор өсч хамгийн амттай, чихэрлэг үр жимс авчрах болно (Алма 32:42-ыг үз).

Хайр

Аврагч хэлэхдээ: “Би та нарт бие биеэ хайрлагтун, Би та нарыг яаж хайрласны адил та нар мөн бие биеэ хайрлагтун гэсэн шинэ зарлиг өгч байна. Хэрэв та нар бие биеэ хайрлах юм бол үүгээр чинь бүх хүн та нарыг Миний шавь нар мөн гэдгийг мэдэх болно” гэжээ (Иохан 13:34-35). Их Эзэн тэдний төлөө хариуцлага хүлээлгэхээр өгсөн тэр хүмүүсийг удирдагчид

хайрлах ёстой. Удирдагчид хүмүүсийг хайрлахдаа тэдэнд үйлчлэх, тэдэнд заах мөн авралынхаа төлөө ажиллахад нь тэдэнд туслахыг хүсдэг билээ.

Дэлхийд хүмүүс удирдагчдыг үйлчлэгчид гэж бодох нь ховор байдаг. Харин Аврагч, удирдагчид удирдаж байгаа хүмүүстээ үйлчлэх ёстой гэдгийг Өөрийн үг хэл, үлгэр дууриаллаар заадаг байв. Тэрээр Арван Хоёрт хэлэхдээ, “Та нарын дунд хэн чинь тэргүүнд байхыг хүснэ, та нарын боол болог” гэжээ (Матай 20:27). Бид бусдад үйлчлэхдээ Их Эзэнд үйлчилж байгаа хэрэг юм (Матай 25:31, Мозая 2:17-г үз).

Дуулгавартай байдал

Дуулгавартай байдал хийгээд Тэнгэрлэг Эцэгийн хүсэл зоригт захирагдахын төгс үлгэр жишээг Есүс Христ харуулсан юм (Матай 26:39; Иохан 5:30-ыг үз). Удирдагчид Их Эзэний зарлигуудыг дуулгавартай дагах шаардлагатай бөгөөд ингэснээрээ тэд бусдад үлгэр дууриал үзүүлж, Ариун Сүнснээс удирдамж хүлээн авахуйц зохистой байж чадна. Дуулгавартай байдал нь Их Эзэнийг хайрлах хайрыг харуулдаг (Иохан 14:15-ыг үз).

Их Эзэний зарлигууд Сүмийн удирдагчдаар дамжин судруудад, түүнчлэн Ариун Сүнсний өдөөлтөөр дамжин илэрхийлэгддэг билээ. Удирдагчид эдгээр зарлигуудыг дуулгавартай дагахад

Их Эзэн тэдэнд дуудлагуудаа бие-лүүлэхэд нь туслах болно.

Эв Нэгдэл

Бусдын нэрийн өмнөөс хийсэн Өөрийнхөө агуу их залбиралд Аврагч Өөрт нь итгэдэг хүмүүс, Тэр болон Түүний Эцэг нэг байд-гийн адилаар тэднийг нэг мэт нэгдмэл байхын төлөөнөө залбир-чээ (Иохан 17:20–23-ыг үз). Эв нэг-дэл бол Сүмийн байгууллага бүхэнд амжилтын гол үндэс юм. Пристийн зэрэгтний болон хавс-ралт байгууллагуудын ерөнхий-лөгчид зөвлөхүүдээсээ ангид ажиллах ёсгүй. Ерөнхийлөгчийн зөвлөлүүд эв нэгдэлтэй байж, хам-таараа зөвлөлддөг тохиолдолд илүү их зүйлийг хийж чадна.

Золислол

Нэг баян залуу эр мөнх амьдралыг өвлөхийн тулд тэрээр юу хийвэл зохихыг Аврагчаас асуужээ. “Зарлигуудыг сахигтун” хэмээн Их Эзэн түүнд хэлэв. Тэрээр өсвөр наснаасаа эхлэн зарлигуудыг сахиж байна гээд мөнөөх залуу эр, “Надад юу дутагдаж байна вэ?” хэмээн асуув. Түүний зүрх сэтгэлд юу байгааг Есүс мэдээд хөрөнгөө зарж, ядууст өгөөд Намайг дага хэмээн түүнд хэлжээ. Гэвч залуу эр “тунигтайгаар холдон явлаа: учир нь тэр маш их хөрөнгөтэй нэгэн байжээ” (Матай 19:16–22-ыг үз).

Энэ явдалд удирдагчид Түүнийг да-гахад бүх зүйлээрээ бэлэн байх ёс-тойг Их Эзэн заажээ. Тэр баян залуу эрийн адилаар эд хөрөнгөө золиос-лох нь удирдагчдаас шаардагдах бөгөөд Их Эзэний ажлыг урагш ахиулахын тулд цаг зав, авьяас чадвар хувийн ашиг сонирхлоо золиослох нь тэднээс шаардагдана. Удирдагчид Их Эзэний төлөө хийгээд Түүний хаант улсын төлөө золиослол хийхэд Тэрээр бүх зүйлд тэднийг адислахаар амладаг билээ (Матай 19:29; С ба Г 97:8–9-ийг үз).

Удирдлагын Зорилго

Зорилгоо Тодорхойлох

Их Эзэнээс удирдамж чиглүүллийг залбирлаар эрэлхийлж Тэрээр тэд-нийг юу хийхийг хүсч байгааг удирдагчид мэдэж авах нь тэдний дуудлагуудад гол чухал зүйл мөн. Сүнсний удирдамжтайгаар зорил-гоо тодорхойлох нь Их Эзэнээс тэ-дэнд өгсөн ажлыг хийхэд нь тэдэнд тусална.

Зорилгыг тодорхойлсны дараа үүн-дээ яаж хүрэхийг удирдагч төлөв-лөх шаардлагатай. Жишээ нь, дүүргийн ерөнхийлөгч дүүргийн хэмжээнд ариун ёслолын цулааны ирцийг нэмэгдүүлэх зорилго тавьж болно. Салбарын ерөнхийлөгчид бүх гишүүдийг ариун ёслолын цуг-лаанд ирж байх талаар өөрсөддөө шаардлага тавихаар хүсэх явдлыг төлөвлөгөөндөө оруулж болно.

Хувь хүн өөртөө зорилго тавьж түүндээ хүрэх явдлыг удирдагчид урамшуулан дэмжих хэрэгтэй. Хувь хүмүүст зориулсан зорилгуудыг удирдагчид зөвлөмж болгож болох хэдий ч тэд зорилгоо өөрсдөө тогтоож, зорилгодоо хүрэх төлөвлөгөөг өөрсдөө хийх хэрэгтэй.

Төлөвлөх ба Ажилд Томилох

Дараах алхмууд нь Их Эзэний ажлыг хийхийн тулд цуглаан, үйл ажиллагаа, үйлчлэлийн төслүүдийг төлөвлөж, зорилгоо тодорхойлоход, түүнчлэн гишүүдийн болон гишүүн бус хүмүүсийн үерхэл нөхөрлөлд пристийн зэрэгтний хийгээд хавсралт байгууллагуудын удирдагчид аль алинд нь туслах болно. Эдгээр алхмууд нь гэрийн багшлалт, Нийгмийн Халамжийн Бүлгийн айлчлагч багшийн ажлыг зохион байгуулахад нь удирдагчдад тусалж, түүнчлэн пристийн зэрэгтний удирдагчдаас салбарын албан тушаалуудад үйлчлүүлэхээр гишүүдийг дуудахад нь туслах болно.

1. Төлөвлөж зохион байгуулах.

Бүх цуглаан, үйл ажиллагаанууд хийгээд зорилтууд нь сайн мэдээний зорилготой байхын тулд удирдагчид тэдгээрийг төлөвлөдөг. Эдгээр төлөвлөгөөнүүдийг хийхэд, санал бодлоо солилцож, зохион байгуулагуулалтад туслуулахын тулд удирдагчид өөрсдийн зөвлөхүүд болон бусад гишүүдэд хүсэлт тавьдаг.

2. Залбирах. Удирдагчид төлөвлөгөө хийж хэрэгжүүлэхдээ Сүнсний өдөөлтөөр дамжуулан удирдамж авахаар залбирдаг. Уг ажилд туслахын тулд хэнийг дуудвал зохих талаар удирдамж авахын төлөө тэд бас залбирдаг.
3. Ажилд томилох. Сайн удирдагч өөрөө бүхнийг хийж чадахгүйг, мөн ингэх ёсгүйг мэддэг учраас өөртөө туслуулахаар бусдыг урьдаг. Тэрээр бусдад чадвараа сайжруулахад нь туслахын тулд тэднийг ажилд томилдог. Тэрээр тэдэнд төлөвлөгөөг тайлбарлаж өгдөг. Удирдагч дараа нь хүн нэг бүрт тусгай ажил үүрэг өгч, энэ ажлын үүргүүд хийгээд түүнийг биелүүлснээр ирэх адислалуудыг тайлбарладаг.
4. Тусалж дэмжих. Удирдагч төлөвлөж, залбирч, мөн хүмүүсийг ажилд томилсны дараа, ажил үүрэг хариуцуулсан хүмүүстээ дэмжин тусалдаг. Удирдагч нь хүмүүсээр хийлгэхийг хүссэн зүйлийнхээ талаар тэдэнд юу мэдвэл зохихыг нь зааж өгч туслах боловч тэр ажил үүргийг өөрөө хийх ёсгүй. Тэрээр ажил үүргийг ямагт өөрийнхөөрөө биелүүлэхийг шахаж шаардахын оронд тэд өөрсдийнхөө санаа бодол хийгээд сүнсний удирдамжийг ашиглахыг нь урамшуулан дэмжиж, хайр, итгэлээ тэдэнд илэрхийлдэг. Зөвхөн зайлшгүй шаардлага гарсан үед л удирдагч

хүн тэднийг дахин чиглүүлэх буюу хийж байгаа зүйлийг нь өөрчлөх хэрэгтэй.

5. Явцад хяналт тавих. Удирдагч нь үүрэг даалгавар өгсний дараа биелэлтийн явцыг үе үе мэдээлж (тайлагнаж) байхыг хүсдэг. Тэрээр энэ асуудлаар зориуд ярилцах, хурал цуглааны үеэр буюу ганцаарчлан уулзаж асуух зэргээр үүнийг хийж болно. Мэдээллийн үеэр удирдагч уг хүнд талархал илэрхийлж, түүнийг чин сэтгэлээсээ магтан урамшуулдаг. Түүнчлэн тэрээр даалгасан ажил үүргийг яаж илүү сайн биелүүлэх тухай ярилцаж болно.
6. Дүгнэх. Даалгасан ажил үүрэг дуусахад удирдагч үүрэг даалгавар авсан хүн болгонтой уг ажлыг дүгнэнэ. Тэрээр баяр талархал илэрхийлж, хийгдсэн ажлын үнэ цэнийн талаар ярилцаж, уг хүнд өөр үүрэг даалгавар өгч болно.

Хэлэлцэх Асуудлын Төлөвлөгөө Бэлтгэх

Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө бол хурлын төлөвлөгөө юм. Энэ нь залбирал, дуулал, яриа, зарлал, ажил хэрэг, үүрэг даалгаврын тайлан буюу мэдээлэл, шинэ шинээр өгөх үүрэг даалгавар, түүнчлэн бусад чухал асуудлуудыг багтаасан байдаг. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг бичгээр гаргах нь хамгийн чухал асуудлууд энд орсныг, түүнч-

лэн хурал цуглааны цагийг зөвөөр ашиглах явдлыг хангасныг мэдэхэд нь удирдагчдад тусалдаг байна. Түүнчлэн хэлэлцэх асуудлын төлөвлөгөө нь хурал цуглааныг зохих ёсоор чиглүүлж, хөтлөн явуулахад нь удирдагчид тусалдаг байна.

Ер нь хурал цуглааныг тэргүүлж байгаа буюу үүнийг хариуцсан хүн хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг бэлтгэдэг. Хурал цуглааны зорилгыг ханган биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай бүх зүйл хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд орсон гэдэгт тэрээр итгэлтэй байх ёстой. Хурлын хэлэлцэх асуудлын төлөвлөгөө бэлтгэсэн хүн хэлэлцэх асуудал тус бүрд ямар хугацаа шаардагдахыг тогтоодог. Хэрэв бүх асуудлыг хэлэлцэхэд цаг хэтэрхий бага байвал тэрээр зарим асуудлыг дараагийн хурлын хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулж болно.

Хурал Цуглаан Хөтлөн Явуулах

Хурал цуглаан хөтлөн явуулж байгаа хүн нь уг хурал цуглааны удирдагч байдаг. Тэрээр залбирах, үг хэлэх, хөгжим удирдах болон уг хурал дээр бусад зүйлүүдийг хийх хүмүүсийн нэрийг зарладаг. Хурал цуглаан хөтөлж байгаа хүн хүндэтгэлтэй байж, Их Эзэний Сүнсээр удирдагдсаны дагуу хурал цуглааныг хөтлөн явуулах ёстой.

Хурал цуглааныг тэргүүлж байгаа хүн үүнийг өөрөө хөтлөн явуулах буюу эсвэл өөрийнхөө удирдлагын

дор үүнийг хөтлөн явуулахыг өөр хэн нэгнээс хүсч болно. Жишээ нь, салбарын ерөнхийлөгч ариун ёслолын цуглаан хөтлөн явуулахыг зөвлөхүүдийнхээ нэгнээс хүсэх буюу чуулгын ерөнхийлөгч чуулгын хурлыг хөтлөн явуулахыг зөвлөхүүдийнхээ нэгнээс хүсч болно. Хавсралт байгууллагууд ч энэ зарчмыг баримталж болно.

Зөвлөлүүд



Их Эзэн Өөрийнхөө хаант улсыг зөвлөлүүдийн зарчмаар захирдаг. Салбарын зөвлөлийн хурал, пристийн зэрэгтний гүйцэтгэх хорооны хурал, түүнчлэн пристийн зэрэгтний болон хавсралт байгууллагуудын ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлууд мэт хурал цуглаануудыг хөтлөн явуулж байгаа хүмүүс дараах чухал зарчмуудыг баримтлах ёстой:

- Ямар нэг онол, таамаглал дээр биш харин сайн мэдээний номлолууд хийгээд зарчмуудад анхаарлаа төвлөрүүлэх.
- Нууц мэдээллийг хэзээ ч задруулахгүй байхыг анхааран хувь хүмүүс, түүнчлэн тэднийг сайн

мэдээнд хэрхэн хүчирхэгжүүлэхэд анхаарлаа төвлөрүүлэх.

- Сонсох бүхий л боломжийг ханган, санал бодлоо чөлөөтэй, илэн далангүй илэрхийлэх явдлыг хөхүүлэн дэмжих. Удирдагчид үг хэлэхийн хамт сонсох ёстой.
- Тэргүүлэгч удирдагчдыг дэмжин тэдний шийдвэрийг хэрэгжүүлэхэд туслах.
- Хайраар, бүхний эрэлт хэрэгцээ хийгээд сайн сайхан байдлын төлөө анхаарал халамж тавих явдлаар удирд.

Нууцыг Хадгалах

Албан ёсны ярилцлагад ч юмуу, эсвэл албан бус ярианы үед мэдэгдсэн хэн нэгний тухай нууц мэдээллийг удирдагчид задлах ёсгүй. Хувь хүний төлдөг аравны нэг болон бусад өргөлүүдийн дүнгийн тухай мэдээлэл зэрэг ярилцлагын дүн хийгээд гэм буруугаа хүлээн зөвшөөрч наманчилсантай холбоотой мэдээллийг маш нууцлан чандлах ёстой. Хэрэв тухайн хүн зөвшөөрөл өгөөгүй бол уг хүн, түүний дотор зөвлөхүүд хийгээд эхнэрийнх нь тухай удирдагчид бусадтай ярилцах ёсгүй. Чандлан нууцалбал зохих нууц асуудлуудын талаар хайхрамжгүй байдаг удирдагчийн хувьд өөрийх нь үйлчилдэг хүмүүсийн гэрчлэл, итгэл суларч болно, түүнчлэн уг удирдагчид итгэх итгэл буурч болно.

Сүмийн Материалуудыг Олж Авах болон Гэр бүлийн Түүхэнд Мэдээлэл Оруулах

Орон нутгийн удирдагчид болон бусад гишүүд Сүмийн материалууд, түүний дотор судрууд, судлах хичээлүүд, Сүмийн сэтгүүлүүд, гармент, ариун сүмийн хувцсыг өөрсдийн Сүмийн хангамжийн төв буюу үйлчилгээний төвөөс, Солт Лейкийн Хангамжийн Төвөөс буюу www.lds.org дахь Сүмийн албан ёсны Интернетийн сүлжээгээр дамжуулан олж авч болно.

Гэр бүлийн түүхийн ажлын талаарх мэдээллийг Сүмийн гэр бүлийн түүхийн Интернетийн www.familysearch.org сүлжээнээс олж үзэж болно.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

